



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/139

Бат-Өлзий сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.18, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт Жогом хороололд Хархорин сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэст эзэмшүүлсэн 6221002673 нэгж талбарын дугаартай, 1000 м² газрын газар эзэмших гэрээгээ цуцлах хүсэлт гаргасны дагуу газар эзэмших эрхийг цуцалсугай.

2. Газар эзэмших эрх, эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон талаар иргэнд мэдэгдэж, холбогдох гэрээ, гэрчилгээг хууль журмын дагуу цуцлахыг Газрын даамал (И.Маралмаа)-д үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан "Газар эзэмшүүлэх тухай" Бат-Өлзий сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/201 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  С.АМГАЛАН